

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2021 онд ОНХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 5.4 хувь нь дутуу хэрэгжсэн бол 19.3 хувь нь огт хэрэгжээгүй байна.

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: СЭА-2022/01-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	
Сүхбаатар сум	Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер Б.Батмөнх
2022 он	Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор С.Баасансүрэн
	Утас: 70363036 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Аудитор Ж.Цогт Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
Аудитор Б.Наранцэцэг Цахим хаяг: Narantsetsegb@audit.gov.mn	

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Дүрслэлийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
Ерөнхий мэдээлэл	7
Нэгдүгээр бүлэг: Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй хэдий ч холбогдох хууль, эрхийн актыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.	7
А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай байхаар төлөвлөхгүй байна.	7
А.2 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдсэн боловч төсөвлөлтийн шаардлага хангагдаагүй төсөл, арга хэмжээг баталдаг зөрчил давтагдсаар байна.	9
Хоёрдугаар бүлэг: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан нийт төсөл, арга хэмжээний 75.3 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.	13
Б.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.	13
Б.2 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 5.4 хувь нь дутуу хэрэгжсэн бол 19.3 хувь нь огт хэрэгжээгүй байна..	15
Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээг үндэслэн санхүүжилтийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд олгосон байна.	18
Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.	19
Аудитын дүгнэлт	20
Зөвлөмж	21
Ирүүлсэн санал, тайлбар	23
Төрийн аудитын газрын тайлбар	24

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон Орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товьёг

<i>Д/д</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
Хүснэгт 1	Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	7
Хүснэгт 2	Өмнөх оноос шилжсэн бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ	15

Дүрслэлийн товьёг

<i>Д/д</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
Дүрслэл 1	Батлагдсан төсөл, арга хэмжээ /хувиар/	8
Дүрслэл 2	Батлагдсан төсөл, арга хэмжээ / төсөвт өртгөөр /	8
Дүрслэл 3	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт /төсөвт өртгөөр/	16
Дүрслэл 4	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт /хувиар/	16

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ <i>Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх,</i> ➤ <i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.</i>
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийг аймгийн ТЕЗ, ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ, ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнууд, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны болон санхүүжилтийн баримт материалуудыг хамруулав.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит.Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд заасан арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан аймаг, сумдын ЗДТГ, аймгийн ОНӨГ, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, худалдан авалт, санхүүжилттэй холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, гүйцэтгэх, хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн

	актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.Үүнд: • Төсвийн тухай хууль, • 2021 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Барилгын тухай хууль, • Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт, • УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, • Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2020 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийг хөгжүүлэх 2021 оны жилийн төлөвлөгөө”, • Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжүүд, • Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт, Б.Наранцэцэг нар 2022 оны 3 дугаар сарын 10-наас 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 461.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12, 10 сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,028.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 81 зэрэг нийт 5,490.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 93 төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна. Эдгээрээс 4,369.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 70 төсөл, арга хэмжээ бүрэн, 268.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 853.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.
--------------------------	---

А бүлэг

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй хэдий ч холбогдох хууль, эрхийн актыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

А.1 Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх, зохистой арга хэмжээг авч байна уу?

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай байхаар төлөвлөхгүй байна.

А.1.1 2021 онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5,490.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 93 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар эцэслэн баталсан байна./ Дэлгэрэнгүйг Судалгаа 1-т харуулав /. Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 461.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээ,
- 10 сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,028.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 81 төсөл, арга хэмжээ гэх мэт.

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хүснэгт № 1 / сая төгрөг /

№	Сумдын нэр	Баталсан төсөл, арга хэмжээ	
		Тоо	Төсөвт өртөг
1	Баруунбүрэн сум	3	99.2
2	Ерөө сум	17	1,708.1
3	Мандал сум	23	1,872.3
4	Орхон сум	1	8.0
5	Сайхан сум	6	210.9
6	Сант сум	1	20.0
7	Сүхбаатар сум	7	118.8


8	Хүдэр сум	20	970.7
9	Цагааннуур сум	2	16.5
10	Шаамар сум	1	4.0
	Нийт дүн	81	5,028.4

Эх сурвалж: 2021 оны сумдын ИТХ-ын тогтоол.


A.1.2 Аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт төсөл, арга хэмжээний 1,703.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалт /аймгийн хөрөнгө оруулалтаар 80.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1, сумдын хөрөнгө оруулалтаар 1,623.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээ/ бол 3,787.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 80 төсөл арга хэмжээ /аймгийн хөрөнгө оруулалтаар 381.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11, сумдын хөрөнгө оруулалтаар 3,405.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 69 төсөл, арга хэмжээ/ нь 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан байна. / Дэлгэрэнгүйг Судалгаа 1-т харуулав /

A.1.3 Дээрх төсөл, арга хэмжээг шинж чанарын хувьд авч үзэхэд 52.5 хувь буюу 42 нь тоног, төхөөрөмж худалдан авах, 21.2 хувь буюу 17 нь их засвар, 18.8 хувь буюу 15 нь барилга байгууламж, 7.5 хувь буюу 6 нь зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээ байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №1 Батлагдсан төсөл,
арга хэмжээ / хувиар /



Дүрслэл №2 Батлагдсан төсөл,
арга хэмжээ / төсөвт өртгөөр /



A.1.4 2021 онд аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл арга хэмжээний 57.5 хувийг /аймгийн 54.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ, сумдын 476.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл, арга хэмжээ/ шууд худалдан авах босго үнээс буюу 20.0 сая төгрөгөөс доош төсөвт өртгөөр хэрэгжүүлэх, хэт жижиглэсэн төсөл арга хэмжээ эзэлж байна.

A.1.5 Хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинж чанартай, байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой 86.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 урсгал засварын ажлыг /аймгийн 36.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ, сумдын 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга

хэмжээ/ баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.24¹ дахь заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-т харуулав/

A.1.6 Улсын төсвийн байгууллагуудад автомашин, тоног төхөөрөмж худалдан авах, байшин барилгыг засварлах зэрэг 14 төсөл, арга хэмжээнд нийт 354.3 сая төгрөгийг баталсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.6.6² дахь заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-т харуулав/

A.1.7 Дээр дурдсанчлан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг хэт жижиглэн, барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлыг бус машин техник, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах, улсын төсөвт байгууллагуудын урсгал зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.

A.2 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулсан уу?

Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдсэн боловч төсөвлөлтийн шаардлага хангагдаагүй төсөл, арга хэмжээг баталдаг зөрчил давтагдсаар байна.

A.2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь улс, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын 2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцсэн, тэдгээрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төлөвлөгдөж, батлагдсан байхаар зохицуулагдсан байдаг.

A.2.2 2021 онд аймгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр баталсан 11 төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй огт уялдаагүй бол дараах сумдын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцээгүй 21 төсөл, арга хэмжээг баталсан байна. Үүнд:

- Ерөө сум нь шинээр хэрэгжихээр батлагдсан 14 төсөл, арга хэмжээнээс 5,
- Мандал сум нь шинээр хэрэгжихээр батлагдсан 20 төсөл, арга хэмжээнээс 7,
- Сайхан сум нь шинээр хэрэгжихээр батлагдсан 5 төсөл, арга хэмжээнээс 4,
- Сант сум нь шинээр хэрэгжихээр батлагдсан 1 төсөл, арга хэмжээнээс 1,
- Хүдэр сум нь шинээр хэрэгжихээр батлагдсан 20 төсөл, арга хэмжээнээс 4 гэх мэт.

A.2.3 Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө

¹ “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ.”

² тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.

оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.1-т “Төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж эрэмбэлэх, үнэлэх” гэж заасан байдаг.

A.2.4 Дээрх заалтын дагуу аймгийн Засаг даргын 2020 оны А/89 дүгээр захирамжаар байгуулагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэлэлцүүлэх, төлөвлөх ажлын хэсэг” нь сумд, хэлтэс, агентлагуудаас 2021 онд хэрэгжүүлэх 183 төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, эрэмбэлэн 28 төсөл, арга хэмжээг 2021 оны аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар бэлтгэсэн байна.

A.2.5 Гэвч аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор 461.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эцэслэн баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дээрх 28 төсөл арга хэмжээнээс машин, тоног төхөөрөмж, тавилга худалдан авах дараах 4 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашин авах,
- Мэргэжлийн хяналтын газарт тоног төхөөрөмж, автомашин авах,
- Татварын хэлтэст тавилга, эд хогшил авах,
- Мандал сумын 1-р сургуульд “Лингафоны танхим”-ын тоног төхөөрөмж авах гэх мэт

A.2.6 Сумдын хувьд ИТХ-ын төлөөлөгч, төр, төсвийн байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 242 төсөл, арга хэмжээг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж, эрэмбэлснээс нэн шаардлагатай гэж үнэлэгдсэн 111 төсөл арга хэмжээний жагсаалтыг гаргаж ИТХ-д оруулан батлуулахаар бэлтгэсэн байна.

A.2.7 Санал авч эрэмбэлэгдсэн нийт 111 төсөл арга хэмжээнээс 48 нь дараах 10 сумын 2021 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан байна. Үүнд:

- Баруунбүрэн сум нь 8 саналаас 3 төсөл, арга хэмжээг,
- Ерөө сум нь 17 саналаас 9 төсөл, арга хэмжээг,
- Мандал сум нь 30 саналаас 13 төсөл, арга хэмжээг,
- Орхон сум нь 2 саналаас 1 төсөл, арга хэмжээг,
- Сайхан сум нь 10 саналаас 1 төсөл, арга хэмжээг,
- Сүхбаатар сум нь 10 саналаас 2 төсөл, арга хэмжээг,
- Хүдэр сум нь 24 саналаас 16 төсөл, арга хэмжээг,
- Цагааннуур сум нь 3 саналаас 2 төсөл, арга хэмжээг,
- Шаамар сум нь 3 саналаас 1 төсөл, арга хэмжээг,
- Сант сум нь 4 саналаас тусгагдаагүй байна.

A.2.8 Хэдийгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх зэрэглэлээр эрэмбэлэх ажил хийгдэж байгаа боловч эдгээрийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, баталгаажуулах ажил хангалтгүй байна.

А.2.9 Аймаг, сумдын ИТХ-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- Барилга байгууламж, их засварын нийт 2,225.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 төсөл, арга хэмжээ /аймаг 81.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4, сумдууд 2,143.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээ/-ний зураг, төслийн даалгаврыг боловсруулж, аймгийн ерөнхий архитектораар баталгаажуулах ёстойгоос 1,579.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээний зураг төслийн даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3.4³, 3.5⁴ дахь заалтуудыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 1-т харуулав/
- Зураг, төсөв нь урьдчилан хийгдсэн байх шаардлагатай нийт 2,054.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний зураг төсвийг төсөв батлахаас өмнө хийсэн бол 1,754.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээ /аймаг 81.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4, сумдууд 1,673.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээ/-ний зураг төсвийг төсөв батлагдсанаас хойш гүйцэтгэж, 170.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг зураг, төсөвгүйгээр сумдын ИТХ-аар /Ерөө 1, Мандал 2, Хүдэр 5/ баталсан байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29.4⁵, 68.2⁶ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав/
- Автомашин, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах нийт 833.8 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээнд зах зээлийн үнийн тооцоо судалгааг хийх шаардлагатай боловч 476.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээ /аймаг 144.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3, сумдууд 332.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээ/-ний техникийн тодорхойлолтыг боловсруулж, үнийн тооцоо судалгааг хийлгүйгээр баталсан байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29.4, 68.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав/
- Тайлант онд шинээр хэрэгжүүлэх аймаг, сумын хөрөнгө оруулалтын нийт 1,915.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний зураг төсөвт магадлал хийлгэхээс 611.7 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээний зураг төслийг магадлалаар баталгаажуулсан бол 1,303.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ /Баруунбүрэн сум 1, Ерөө сум 1, Мандал сум 5, Сайхан сум 1, Хүдэр сум 3/-ний зураг төсөвт магадлал хийлгэж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 25.2, Авто замын тухай хуулийн 19.2.5, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх

³ Архитектор төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектор батална.

⁴ Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектор төлөвлөлийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

⁵ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”

⁶ Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

дүрэм”-ийн 6.3 дахь заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав./

- Инженер-геологийн дүгнэлтэд магадлал хийлгэх шаардлагатай барилга байгууламжийн 1,217.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээнээс 663.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний инженер-геологийн дүгнэлтийг магадлалаар баталгаажуулж, 553.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ /Мандал сумын 133.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, Хүдэр сумын 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ/-ний инженер-геологийн дүгнэлтийг магадлалаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4⁷, Барилгын тухай хуулийн 25.2⁸ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 1-м харуулав/
- Шинээр эхлэх барилга байгууламжийн цахилгаан, дулаан, ус хангамжийн техникийн нөхцөлийг иж бүрэн аваагүй нийт 427.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээ /аймаг 28.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, Баруунбүрэн сум 73.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Ерөө сум 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, Мандал сум 305.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ/-г хэрэгжүүлэхээр аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.2⁹ дахь заалтыг зөрчсөн байна.

А.2.10 Дээр дурдсанчлан зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй, магадлалаар баталгаажуулаагүй, газрын зөвшөөрөл болон техникийн нөхцөл, инженер-геологийн дүгнэлтийг иж бүрэн хийгээгүй төсөл арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж баталсан нь ажлын явц удаашрах, гүйцэтгэлийн чанарт муугаар нөлөөлөх, санхүүжилтийг үндэслэлтэй төлөвлөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

А.2.11 Зарим сумд нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэр, байршил, хэрэгжих хугацааг тусгаагүй, төсөл, арга хэмжээг давхардуулан баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 33.2.6¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Сант сумын ИТХ-ын 2021 оны 20 дугаар тогтоолоор 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1, Шаамар сумын ИТХ-ын 2021 оны 29 дүгээр тогтоолоор 4.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээний нэр, байршил, хэрэгжих хугацааг тусгаагүй баталсан,
- Мандал сумын ИТХ-ын 2021 оны 24 дүгээр тогтоолоор баталсан 300.0 сая төгрөгийн “Авто зам, барилгын зураг төсөв боловсруулах” төсөл, арга хэмжээнд багтсан “ЗДТГ-ын барилгын дулааны сүлжээний схем зургийн үнэ”

⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт ... хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁸ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.4. инженер-геологийн дүгнэлт, геодезийн зураглалд

⁹ Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй. Үүнд: 7.2.1.эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх.

¹⁰ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн

төсөл, арга хэмжээг 10.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр давхардуулан баталсан байна.

A.2.12 Сүхбаатар сум нь өмнөх оноос он дамжин хэрэгжихээр баталсан 14.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “1-р багт хашааг үргэлжлүүлэх” төсөл, арга хэмжээ нь иргэний эзэмшилд бүртгэлтэй хашааг солих ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 4.1.24¹¹ дахь заалтыг зөрчсөн байна

A.2.13 Зарим сумд гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах аргаас зайлсхийх зорилгоор ижил төрлийн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Ерөө сум нь 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Ерөө болон Бугант тосгонд явуулын вагончик худалдан авах төсөл, арга хэмжээг 2 хуваасан,
- Сайхан сум нь 38.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Сайхан сумын ЗДТГ-ын урсгал болон дээврийн засварын төсөл, арга хэмжээг 2 хуваасан,
- Хүдэр сум нь 28.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ЭМТ-д тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах төсөл, арга хэмжээг 3 хуваасан байна.

A.2.14 Аймаг, сумд нь 2021 оны 7-8 дугаар сард төсвийн тодотгол хийж, нийт 1,287.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 47 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нэмж баталсан байна.

A.2.15 Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэн баталж байгаа нь худалдан авах ажиллагаа оройтох, улмаар тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэж байна.

Б бүлэг

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан нийт төсөл, арга хэмжээний 75.3 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу байгуулсан уу?

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.

¹¹ “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ.”

Б.1.1 2021 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулах аймаг сумдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 5,197.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 84 төсөл / тайлант онд шинээр эхлэх 80, өмнөх онд худалдан авах ажиллагаа нь зарлагдалгүйгээр шилжиж ирсэн 4 төсөл, арга хэмжээ / арга хэмжээний худалдан авах ажиллагааг дараах аргуудаар зохион байгуулахаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Үүнд:

- 3,263.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар,
- 1,133.6 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар,
- 459.0 сая төгрөгийн 40 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар,
- 342.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар гэх мэт. /Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав./

Б.1.2 Үүнээс 2021 онд хэрэгжсэн 4,343.3 сая төгрөгийн өртөг бүхий 37 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 3,171.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 860.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, 312.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар сонгон шалгаруулж, 441.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 2-т харуулав/

Б.1.3 Харин Хүдэр сум төсвийн тодотголоор зураг, төсөвгүйгээр нэмж батлагдсан 56.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Замын ажлын нэмэлт ажил /брокер/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалгүйгээр “Сумын төвд зам тавих, тэмдэг тэмдэглэгээ хийх” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч Нобле роуд ХХК-тай нэмэлт ажлын гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

Б.1.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн, нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын болон зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журмаар худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 4,343.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээний тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулж, худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд мэдээлсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 2-т харуулав/

Б.1.5 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 11 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны “Үнэлгээний хороо”-г аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бол сумдын хувьд “Ажлын хэсэг”-ийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Б.1.6 Үнэлгээний хороо болон ажлын хэсэгт томилогдсон нийт 206 /давхардсан тоогоор/ гишүүнээс 15 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

Б.1.7 Аймгийн ОНӨГ нь аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1¹²-д заасны дагуу тайлагнаж, эхний хагас жилийн болон жилийн эцсийн тайланг Сангийн яаманд цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн уу?

2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 5.4 хувь нь дутуу хэрэгжсэн бол 19.3 хувь нь огт хэрэгжээгүй байна.

Б.2.1 Аймгийн болон сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5,490.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 93 төсөл, арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөснөөс 4,369.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 70 төсөл, арга хэмжээ бүрэн, 268.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 853.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Б.2.2 Өмнөх оноос шилжиж ирсэн аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1, сумдын 12 зэрэг нийт 1,703.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээнд 2021 онд гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт 1,516.3 сая төгрөгийг олгох төсөв батлагдсанаас 9 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1,406.7 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгосон бол хэрэгжиж дуусаагүй 4 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 109.7 сая төгрөгийг олгоогүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Өмнөх оноос шилжсэн бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ

Хүснэгт № 2 / сая төгрөг /

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн	Тайлбар
1	Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлэх /Аймгийн хөрөнгө оруулалт/	80.0	80.0	Цар тахлын улмаас нийлүүлэгдэх боломжгүй
2	Орон нутаг судлах музей, Хэрх тосгоны спорт заал, Зүүнхараа политехник коллежийн спорт заалны барилгын зураг төсөл боловсруулах /Мандал сум/	10.9	10.9	Гэрээ гүйцэтгэх хугацааг сунгаагүй. Гэрээ цуцлах мэдэгдэл хүргүүлсэн.
3	1-р багт хашааг үргэлжлүүлэх /Сүхбаатар сум/	14.0	14.0	2021 онд санхүүжилт олгоогүй
4	Буурын голын тоглоомын талбайн тохижилт /Сүхбаатар сум/	20.0	4.8	2021 онд санхүүжилт олгоогүй


¹² Төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах хугацаанд ирүүлнэ. 3.1.1.Хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор, 3.1.2.Бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор.

	Дүн	124.9	109.7	
--	------------	--------------	--------------	--

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

Б.2.3 Аймаг болон сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 3,787.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 80 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас 2,791.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төсөл, арга хэмжээ гэрээт хугацаанд бүрэн хэрэгжсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 3-т харуулав/

Дүрслэл №3-4



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

Б.2.4 Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосонтой холбоотойгоор барилгын материал хэрэгслийн үнэ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааг оройтуулж зохион байгуулж, гэрээ байгуулсан зэргээс шалтгаалан 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Мандал сумын 2, Хүдэр сумын 2 зэрэг нийт 248.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 3-т харуулав/

Б.2.5 Аймаг, сумд нь төсвийн тодотголоор төсөл, арга хэмжээг нэмж баталснаас худалдан авах ажиллагааны хугацаа оройтсон, огт зарлаагүй, зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй гэх шалтгаанаар тайлант онд шинээр хэрэгжих 748.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 15 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг Судалгааг 3-т харуулав/

Б.2.6 2021 онд хэрэгжсэн нийт 2,789.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37.1.4¹³, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга

¹³ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

захиалагчийн дүрэм”-ийн 3.12¹⁴-т заасны дагуу “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь гэрээний үндсэн дээр явцын болон техникийн хяналтыг ажлын үе шат бүрд хэрэгжүүлж, баталгаажуулсан байна.

Б.2.7 Тус газрын дарга, хяналтын инженерүүд нь Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.9¹⁵, 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2¹⁶-т заасны дагуу үе шат бүрд хяналт хийж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, хяналтын тайлангаар баталгаажуулсан байна.

Б.2.8 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн, төсөвт өртөг багатай, автомашин, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах нийт 1,675.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг аймаг, сумдын ЗДТГ хэрэгжүүлсэн байна.

Б.2.9 Харин сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 172.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээнд захиалагчийн зүгээс хяналт огт хэрэгжүүлээгүй байна.

Б.2.10 Барилгын тухай хуулийн 37.1.5¹⁷, “Барилга захиалагчийн дүрэм”-3.1.4¹⁸-т заасны дагуу зураг, төсөв зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч компаниудаар гүйцэтгүүлсэн байна.

Б.2.11 Зураг, төсөв зохиогчийн хяналтыг БХБ-ын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.2.3¹⁹, Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.3²⁰-т заасны дагуу төсөл, арга хэмжээний үе шат бүрд хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг арилгуулан, зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Б.2.12 Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь

¹⁴ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

¹⁵ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

¹⁶ Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.

¹⁷ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

¹⁸ Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

¹⁹ Зохиогчийн хяналтыг барилга байгууламжийн байршил, онцлогоос хамааруулан гүйцэтгэнэ: 3.2.3 барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих.

²⁰ Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт шалгалт хийгээгүй, хэрэгжилт, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

Б.2.13 Аудитын явцад нийт 6 суманд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг тулган баталгаажуулахад бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагуудаас санал, гомдол гараагүй бөгөөд хүчин чадал, зориулалтын дагуу ашиглаж байна.

Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна уу?

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээг үндэслэн санхүүжилтийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд олгосон байна.

Б.3.1 Тайлант онд аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 93 төсөл, арга хэмжээнд нийт 5,303.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоос бүрэн хэрэгжсэн 73 төсөл арга хэмжээнд 4,135.7 сая төгрөг, дутуу хэрэгжсэн 5 төсөл арга хэмжээнд 83.9 сая төгрөг зэрэг нийт 4,219.6 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгож, 224.2 сая төгрөгийг аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд байршуулан, сумдын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 859.8 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Б.3.2 Аймгийн ЗДТГ-ын СТСХ болон сумдын ЗДТГ-ын Санхүүгийн алба нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.9²¹-д заасны дагуу төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, санхүүжилт хүссэн материалыг хянаж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгохоор зохицуулагдсан байна.

Б.3.3 Гэвч 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баруунбүрэн сумын эмнэлгийн сантехникийн засвар төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардалд 0.3 сая төгрөгийг магадалшгүй ажлын төсөв, фото зураг зэрэг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр олгосон нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.17²²-д заасныг зөрчсөн байна.

²¹ төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлж, санхүүжилт олгох.

²² Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.

Б.3.4 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно” гэж заасны дагуу Мандал сум нь барилга байгууламж, их засварын 6 төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгаж, нийт 45.5 сая төгрөгийн барьцааг байршуулсан бол аймаг болон бусад сумд барьцааны нөхцөлийг гэрээнд тусгаагүй, барьцаа хөрөнгө байршуулаагүй байна.

Б.3.5 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтын дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжиж дууссан 70 төсөл, арга хэмжээний нийт 4,343.3 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна.

Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчлийг арилгуулсан уу?

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.

Б.4.1 Өмнөх аудитаар 10 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмж бүрэн, 4 зөвлөмж дутуу хэрэгжсэн бөгөөд дараах 3 зөвлөмж огт хэрэгжээгүй байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсвийг хэт жижиглэсэн болон тоног төхөөрөмж, машин техник худалдан авах төсөл арга хэмжээнд бус бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх,
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсвийн тодотгол хийхгүй байх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх,

Б.4.2 Өмнөх аудитаар өгсөн дээрх 3 зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр алдаа, зөрчлийг тайлант онд давтан гаргасан тул МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн хэмжээнд нийт **3,004.0 сая төгрөгийн** зөрчил илэрч албан шаардлага хүргүүлээ.

Үүнд:

- 1,754.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээний зураг төсвийг төсөв батлагдсанаас хойш гүйцэтгэсэн,
- 655.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээг зураг, төсөв, тооцоо судалгаагүйгээр аймаг, сумдын ИТХ-аар баталсан,
- 350.0 сая төгрөгийн /давхардсан дүнг хасаж тооцов/ төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээний зураг төсөлд магадлал хийлгэж, баталгаажуулаагүй,
- 4 /давхардсан дүнг хасаж тооцов/ төсөл, арга хэмжээний инженер-геологийн дүгнэлтийг магадлалаар баталгаажуулаагүй,
- Техникийн нөхцөлийг иж бүрэн аваагүй 5 /давхардсан дүнг хасаж тооцов/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, батлуулсан,
- Мандал, Сант, Шаамар сумд нь 34.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний нэр, байршил, хэрэгжих хугацааг тусгаагүй болон төсөл, арга хэмжээг давхардуулан баталсан,
- Сүхбаатар сум 14.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “1-р багт хашааг үргэлжлүүлэх” төсөл, арга хэмжээг иргэний эзэмшилд бүртгэлтэй хашааг солих ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн,
- Ерөө, Сайхан, Хүдэр сумд нь гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах аргаас зайлсхийх зорилгоор нийт 86.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ижил төрлийн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэхээр төлөвлөсөн,
- Хүдэр сум нь төсвийн тодотголоор батлагдсан 1 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар тендер шалгаруулалгүйгээр шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн,
- Зарим сумд нь 110.0 сая төгрөгийн /давхардсан дүнг хасаж тооцов/ төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээнд захиалагчийн зүгээс хяналт огт хэрэгжүүлээгүй,

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай байхаар төлөвлөхгүй байна.
- Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдсэн боловч төсөвлөлтийн шаардлага хангагдаагүй төсөл, арга хэмжээг баталдаг зөрчил давтагдсаар байна.
- Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэн баталж байгаа нь худалдан авах ажиллагаа оройтох, улмаар тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэж байна.

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.
- 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 5.4 хувь нь дутуу хэрэгжсэн бол 19.3 хувь нь огт хэрэгжээгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн болон зураг төсөв зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, баталгаажуулсан байна.
- Аймгийн ТЕЗ-ийн дотоод аудит болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт шалгалт хийгээгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээг үндэслэн санхүүжилтийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд олгосон байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэлгүйгээр, зөрчлийг давтан гаргасан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж болон сумдын Засаг дарга нарт:

- ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг улс, аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, Засгийн газрын болон аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөж байх.
- ОНХО-ын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгуулахаар өргөн мэдүүлэх.
- ОНХО-аар хэт жижиглэсэн, урсгал зардлын шинж чанартай бус бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх.
- ОНХО-ын төсөл арга хэмжээг нэмэгдүүлэн хэрэгжүүлэхээр төсвийн тодотгол хийхгүй байх.
- ОНХО-ын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүнг үнэлж, үнэлэлт дүгнэлт өгч байх.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа болон сумдын ЗДТГ-ын дарга нарт:

- 2021 онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан боловч гэрээт хугацаанд ашиглалтад оруулаагүй төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангах.

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

- Үнэлгээний хороо”, “Ажлын хэсэг”-т ажиллах гишүүдийн “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бүрэн гаргуулж, гарын үсгээр баталгаажуулж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР

С.БААСАНСҮРЭН

АУДИТОР

Ж.ЦОГТ

АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХОХБТХ-ЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-2223

2022.04.29 № 01/450
танай _____-ны № _____

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ЭНХТУЯА ТАНАА

Аудитын тайлангийн төсөлд тайлбар хүргүүлэх тухай

Тайлант 2021 онд Ковид-19 цар тахалтай холбоотой улсын хил, гаалийн үйл ажиллагааг түр хаасан, улмаар импортын барилгын материалын нийлүүлэлт буурч үнийн өсөлт үүссэн зэрэг нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ихээхэн нөлөө үзүүлсэн.

Иймээс Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/4063, 11 дүгээр сарын 04-ний өдрийн 1/4353 дугаар албан бичгүүдээр болон сургалт, зөвлөгөөнөөр цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлж барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн эдийн засгийн хүндрэлийг даван туулах, чадамжийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор санхүүжилтийг уян хатан шийдвэрлэх, ажлын гүйцэтгэлд нийцүүлж гүйцэтгэлийн баталгаа, чанарын баталгаа чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх зэргээр дэмжиж ажиллах чиглэл өгсөн.

Түүнчлэн гүйцэтгэгч байгууллага ажил гүйцэтгэж дуусан Улсын комисс ажиллуулах хүсэлт өгснөөс хойш комиссын бүрэлдэхүүн бүрдэж, техникийн болон Улсын комисс ажиллахад хугацаа алддаг тул гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу гэрээний үүргийг биелүүлсэнд тооцож алданги ногдуулаагүй болно. Иймээс “Гүйцэтгэгчид 37.4 сая төгрөгийн алданги ногдуулаагүй байна.” Гэсэн зөрчлийг алдаа, зөрчлийн дүнгээс хасаж өгөхийг хүсье.

“Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллаж, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Ж.САЙНЦОГ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой тайлбар, санал ирээгүй тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулахгүйгээр шийдвэрлэв.